



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Улс, Нийслэлийн тэргүүний сайн малчин,  
фермер, тариаланчид хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сар шинийн баярыг тохиолдуулан "Улсын аварга фермер", "Нийслэлийн тэргүүний сайн малчин", "Нийслэлийн тэргүүний фермер", "Нийслэлийн тэргүүний тариаланч"-аар шалгарсан дүүргийн иргэдэд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээнд зарцуулагдах төсөв 2.578.679 /хоёр сая таван зуун далан найман мянга зургаан зуун далан есөн/ төгрөгийг Засаг даргын Тамгын газрын зардлаас гаргахыг Тамгын газрын ахлах нягтлан бодогч /Г.Золзаяа/-д зөвшөөрсүгэй.

3. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс /Б.Оюунбилэг/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ГЭТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.БАЯРАА

1180200156